

Дээрхээс дүгнэн үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үйлдэгддэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг тодорхой үе шаттайгаар үр нөлөөтэй зохион байгуулах, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг олж илрүүлэхэд Пенитенциар криминологийн шинжлэх ухааны байр суурьнаас хандах, хорих анги, албад өөрсдийн онцлогт тохирсон пенитенциар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулж үе шаттай, тасралтгүй явуулах нэн шаардлагатай байна. Ингэхдээ тодорхой сулалгаанд үндэслэсэн оновчтой арга ажиллагааг ашиглан криминологид, судлаачдаар хийлгэх энэхүү үйл ажиллагаандаа хорих ангийн практик ажилтнуудын татан оролцуулж тэднийг уг арга ажиллагаанд сургаж бэлтгэх нь зүйтэй юм.

Мөн хорих байгууллагад аюулгүй байдлын алба нэгжийн бүтцийг бий болгож уг алба нь хорих байгууллагад явуулж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан чиглүүлж, дээр дурьдсан субъектүүдийн хоорондын уялдаа холбоог ханган, гэмт хэрэгтэй тэмцэх ажлын нэгдсэн болон тусгайлан төлөвлөгөөг батлан, хяналт тавин ажиллах нь үр дүнтэй гэж үзэж байна.

* * *

Р.УУГАНБАЯР



Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн
сургуулийн Аюулгүй
байдлын тэнхимийн
багш, ахмад

ЯЛТАНД ОНОГДУУЛАХ САХИЛГЫН ШИЙТГЭЛ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олон нийтээс тусгаарлаж, тодорхой хугацаагаар хязгаарлагдмал орчинд албадлагаар тогтоон барьдаг өөрөөр хэлбэл гэмт хэрэгтнүүдийн оршин амьдрах нийгмийн бичил орчин болдог.¹⁵⁹

Монгол Улсад хорих ял шийтгэгдэж хорих ял эдэлж буй 60000 гаруй ялтан байдаг бөгөөд сүүлийн арван жилийн байдлаар төвлөрсөн хорих ангиудад нийт 5998 ялтан зөрчил гаргаж сахилгын шийтгэл эдэлсэн байна. Үүнээс үзэхэд 30% гаруй хувьд нь гар утас ашигласан зөрчил зонхилж байгаа бөгөөд албан хаагчийн шаардлага биелүүлээгүй 844, архи болон согтууруулах ундааны зүйлс хэрэглэсэн 1060, хорих ангийн дотоод журам зөрчсөн 479, бусдын биед гэмтэл учруулсан 474 ялтан гэх зэрэг зөрчлүүд зонхилж байгаа бөгөөд сүүлийн 5 жилийн байдлаар ялтны гаргасан зөрчилд оногдуулсан сахилгын арга хэмжээ жил жилээр огцом өсч байгаа нь судалгаагаар харагдаж байна. 2008 онд гэхэд нийт

¹⁵⁹Г.Тамир. "Онцгой дэглэмтэй хорих ангид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагаа, онцлог". Илтгэл.УБ., 2014

773 ялтанд сахилгын арга хэмжээ оногдуулж байсан бол 2012 оны байдлаар 1956 ялтанд сахилгын арга хэмжээ оногдуулсан байна. Иймд ялтны гаргасан зөрчил жил жилээр хурдацтай нэмэгдэж байгаа явдлыг зогсоох хэвийн хэмжээнд барих явдал нь нэн тэргүүний шаардлагатай чухал асуудал болоод байгаа юм.

Ялтны зөрчил нь хорих ангийн хэвийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг гэж үзэж болно. Тухайн хорих ангид ял эдэлж буй ялтны хөдөлмөрлөх, хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэх үйл ажиллагааг хорих анги, ангийн удирдлага, албан хаагчид шууд хариуцан явуулдаг бөгөөд ялтны гаргасан зөрчлөөс хамааран тухайн ялтны ажлын байр эзэнгүйрэх, тус ангийн хэвийн үйл ажиллагаа доголдох зэрэг асуудлууд үүсдэг. Иймд ялтны зөрчил гаргах шалтгаан, гаргасан зөрчлийн хор аюул хамрах хүрээнээс шалтгаалан хорих ангийн даргын тушаалаар сахилгын шийтгэл оногдуулдаг. Оногдсон сахилгын шийтгэлийн арга хэмжээ нь тухайн ялтныг гэмшүүлэх дахин зөрчил гаргуулахгүй байх талаар ойлгуулах, түүгээр дамжуулан бусад ялтны сэтгэл зүйд нөлөөлж, цочрол өгөх зэрэг олон талын хийсвэр ухагдахуун агуулдаг боловч практик үйл ажиллагаанд энэ нь хэрэгжихгүй байгаатай холбоотой ялтны гаргах зөрчил болон гэмт хэрэг буурахгүй байгаа билээ.

Сүүлийн жилүүдэд ялтны эрхийг хамгаалах, хүний эрх эрх чөлөөг дээдэлсэн бодлогууд ихээр явагдаж хорих анги болон бусад салбар нэгжүүдэд ялтны эрхийг хангах хамгаалах олон талын үйл ажиллагааг төрийн болон төрийн бус

байгууллагууд хэрэгжүүлж ирсэн бөгөөд үүнтэй холбоотой ялтанд оногдуулах сахилгын шийтгэлийн асуудал хөндөгдөж байна.

Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 127 дугаар зүйлд ялтанд оногдуулах сахилгын шийтгэлийн талаар эрх зүйн зохицуулалт хийгдсэн байдаг. Ялтан хууль тогтоомж, хорих ангид тогтоосон дэглэм, журам зөрчсөн нь гэмт хэргийн шинжгүй бол түүнд хорих ангийн даргын шийдвэрээр дараах сахилгын шийтгэл оногдуулна.

- Ээлжийн бус ажил хийлгэх
- Хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх
- Сахилгын байранд хорих
- Тухайн улирал эсхүл жилд олгосон шагналын хоногийг хасах.¹⁶⁰

Ялтанд ээлжийн бус ажил хийлгэх сахилгын шийтгэл оногдуулдаг боловч хорих ангиудад төдийлөн хэрэгжиж байгаа нь цээрлүүлэлтийн шинжийг агуулж чаддаггүй. Учир нь хорих ангийн үйлчилгээнд сахилгын шийтгэлийн хэлбэрээр ажилуулахыг НҮБ ээс батлан гаргасан Хоригдлуутай харьцах наад захын жишиг дүрэмд хориглосон заалт байдаг. Нөгөөтэйгүүр ялтны хөдөлмөрлөх цаг хугацааг тогтоосон эрх зүйн зохицуулалт ч байдаг. Сүүлийн 5 жилийн судалгаанаас үзэхэд нийт 2544 ялтанд ээлжийн бус ажил хийлгэх сахилгын шийтгэлийг оногдуулсан тоо баримт байна. Ялтныг хорих дэглэмээс хамаарч сахилгын шийтгэл оногдуулах эрх зүйн орчин өөр өөр байна. Хорих ял эдлүүлэх дэглэм нь ялтныг хүмүүжүүлэхэд нөлөөлөөд зогсохгүй

¹⁶⁰ Монгол Улсын Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх тухай хууль. 2002 он

хорих анги, гяндан, баривчлах байранд ялтнуудаас гэмт хэрэг шинээр үйлдэхээс урьдчилан сэргийлэх явдлыг хангана. Хорих ял эдлүүлэх дэглэм нь ялын цээрлэл үзүүлэх шууд илэрхийлэл болохын хувьд иж бүрэн эрхийн хязгаарлалтуудад илэрч байгаа ялтны эрхийн зүйн байдлыг тодорхойлдог. Энэ байдал нь ялтан хорих ял эдэлж байх хугацаандаа иргэний эрхээ бүрэн эдлэх боломжоо хязгаарлуулж байгаа нь ялын цээрлэл амсаж байгаа хэрэг юм.

Дэглэмийн тусламжтайгаар ялын цээрлэлийг хэрэгжүүлэх нь гол зорилго гэж үздэг. Цээрлэл нь аливаа эрүүгийн ялд байх элемент бөгөөд энэ нь гагцхүү хүмүүжүүлэх агуулгатай юм. Өөрөөр хэлбэл ялтанд цээрлэл үзүүлэх замаар дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй байлгахад Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан ялын зорилго оршино.

Эрхийн хязгаарлалтууд нь цээрлэлийн агуулгатай боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн нөлөөллийн бусад арга хэмжээнүүдтэй нягт холбоотойгоор хэрэгжиж, хорих ял эдлэгсдийг нийгэмд тогтоосон нийтээрээ дагаж мөрдөх хууль ёсыг сахин биелүүлдэг, аливаа асуудалд тэвчээртэй ухаалаг ханддаг болгон ялтныг хүмүүжүүлдэг болохыг практик харуулж байна. Үүнээс үндэслэн дэглэмийг зөвхөн ялтныг цээрлүүлэх хэрэгсэл гэж үзэж болохгүй бөгөөд дэглэм нь бүхэлдээ тэдний үйлдсэн гэмт хэрэг, зан байдлын хувьд харилцан адилгүй олон тооны ялтнуудыг нэг дор амьдрах нөхцлийг бүрдүүлээд зогсохгүй ялтан бүрийн алхам тутамдаа биеэ авч явах журам, амьдралын хэв маягийг нарийвчлан тогтоох замаар тэднийг хамтын

хөдөлмөр хийлгэж, улмаар хөдөлмөрөөр хүмүүжүүлэх, тэдний дунд хүмүүжлийн ажил, боловсролын сургалт, хөдөлмөрийн дадлага олгох сургалт зохион байгуулах нөхцлийг хангаж байдгаараа хүмүүжлийн чухал хэрэгсэл юм. Олон хүн цугларсан газар тэр тусмаа гэмт хэрэгтнүүдийн бөөгнөрөл болсон хорих байгууллагад хатуу дэг журамгүйгээр ялын зорилго хангагдахгүй харин ч тэдний дундаас гарах зөрчил гэмт хэрэг гарах нөхцөл бололцоог олгож буй хэрэг гэдгийг 90 жилийн түүхэн туршлага харуулж байна.

Дээрхи дэглэмийн талаар хууль зүйн ухааны доктор, профессор С.Жанцан "Дэглэм нь ялтны зүгээс гаргаж болох хууль бус үйл ажиллагааг хязгаарлаад зогсохгүй түүнийг нийгмийн идэвхитэй гишүүн болгон эрх чөлөөт амьдралд буцаан оруулах замаар амьдралын ердийн нөхцөлд үргэлжлүүлэн хүмүүжүүлэхэд чиглэгдсэн чухал элементүүдийг өөртөө агуулдаг. Жишээ нь: ялтан тогтоосон цагийн хуваарийг ягштал биелүүлэх, өглөө бүр биеийн тамрын дасгал хийх, орчны хүмүүсийг хүндэтгэдэг, зөв боловсон харьцдаг болохыг шаардсан дэглэмийн элементүүд цэвэр хүмүүжлийн агуулгатай байна"¹⁶¹

Гянданд ял эдэлж буй ялтан анх удаа сахилгын зөрчил гаргасан тохиолдолд түүнд ээлжийн бус ажил хийлгэх сахилгын шийтгэл оногдуулах нь зохимжгүй бөгөөд гянданд хоригдож буй ялтнуудад хөдөлмөр эрхлэх боломж бололцоог одоогоор манайд

¹⁶¹ С.Жанцан О.Энхбат "Хорих ял эдлүүлэх дэглэм, түүнийг хангах хэрэгсэлүүд" УБ..1989 он..13 дах тал

хэрэгжүүлж байгаа зохицуулалт болон хэрэгжилт алга байна.

Ялтны хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх сахилгын шийтгэл нь зарим ялтанд оногдуулахад мөн учир дутагдалтай байна. Хорих ангийн аж ахуй үйлчилгээнд жирийн дэглэмтэй ялтан ажиллуулах тухай зохицуулалт манайд байдаг ба чанга, онцгой дэглэмтэй хорих ангийн үйлчилгээ аж ахуйд ял эдэлж буй ялтны хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх сахилгын шийтгэл оногдуулсан боловч энэ хэрэгжихэд учир дутагдалтай иймд манай улсын хувьд сахилгын хорих байранд хорих, шагналын хоногийг хасах сахилгын шийтгэлийн төрлүүд бүрэн утгаараа хэрэгждэг. Сүүлийн 5 жилд 564 ялтны хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх арга хэмжээ авсан бол 2393 ялтан сахилгын хорих байранд хорих 1155 ялтны шагналын хоног хасах сахилгын арга хэмжээ авагдсан байна.

ШШГТухай хуулийн 127.2. Насанд хүрсэн эрэгтэй ялтныг 30 хүртэл хоног, насанд хүрээгүй болон насанд хүрсэн эмэгтэй ялтныг 15 хүртэл хоног, онцгой тохиолдолд насанд хүрсэн эрэгтэй ялтанг 60 хүртэл хоног, насан хүрээгүй болон насанд хүрсэн эмэгтэй ялтанг 30 хүртэл хоног сахилгын байран хорихоор заасан байдаг¹⁶². Мөн хорих ангийн аюулгүй байдлыг хангах, ялтны дундаас гарч болзошгүй гэмт хэрэг зөрчилөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ангийн жижүүрийн шийдвэрээр тухайн ялтанг 72 цаг хүртэл сахилгын хорих байранд шилжүүлж болдог бөгөөд ялтанг

сахилгын хорих байранд хорих тохиолдолд заавал эмчид үзүүлж тэмдэглэл үйлдсэн байх шаардлагатай байдаг.

Ялтны дундаас гарч буй зөрчлийг бууруулах гол үндсэн арга бол ялтныг хүмүүжүүлж, нийгэмшүүлэх явдал юм. Хорих ангийн нөхцөлд ялтныг хүмүүжүүлэх гол арга бол хөдөлмөрлүүлэх нь зөв оновчтой арга юм. Эрүүгийн хуулийн тодорхой нийгэмд аюултай, эс аюултай үйлдлийг хийж бусдад ямарваа нэгэн хэлбэрээр эд материалын болон сэтгэл санааны хохирлыг их, бага хэмжээгээр учруулж, үүний улмаас Үндсэн хуульд заасан заяамал эрхээс бусад тодорхой эрхүүдийг хязгаарлаж, төрийн хуулийн дор суугаа этгээдийн талаарх анхаарах зарим асуудлуудыг авч үзэх нь зүйтэй. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгчийн хувьд шийтгэх тогтоол гарсан бол "ялтан" гэж нэрлэх болсон. Тухайн ялтныг хорьж цагдсанаар гэмт үйлдлийг ойлгуулах, нийгмийн хор уршиг аюулыг бүрэн гүйцэт таниулах, цаашид дахин гэмт хэрэг үйлдэхгүй гэх баталгаа бүрэн хангагдаж чадахгүй байна. Иймд дээрх илтгэлийнхээ хүрээнд дараах саналуудыг дэвшүүлж байна.

1. Хорих ял эдлэгсдээс үйлдэж буй зөрчил, гэмт хэрэг бүгдийг цаг алдалгүй илрүүлэн таслан зогсоож, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг шуурхай явуулан шийдвэрлэж зөрчлийн болон ялтны хувийн байдалд нь тохирсон хариуцлагыг эргэлт буцалтгүй заавал ноогдуулах механизмыг нэг мөр төлөвшүүлэх. Учир нь хорих байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн мэдээнд гэмт хэргийн шинжтэй зарим

¹⁶² Монгол Улсын Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх тухай хууль. 2002 он